

**БАТЛАВ:**  
**ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК-ИЙН**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**Г.БАЛЖИННЯМ**

Огноо: 2019.10.16



***IP МОДУЛЬ, ШИЛЭН КАБЕЛИЙН ХУВИРГАГЧ, ЦАХИМ ХЭРЭГСЛИЙН***  
***МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ***

**Тендер шалгаруулалт: ДҮТ/201902018**

**Төслийн дугаар: ДҮТ-2019-04-18**

**УЛААНБААТАР ХОТ**  
**2019 ОН**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос ***IP модуль, шилэн кабелийн хувиргагч, цахим хэрэгслийн материал*** -ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Уг тендер нь шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул <https://tender.gov.mn> хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07-дугаар, тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын /2014 оны 32 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан/ дагуу зохион байгуулж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын 6.2 –р заалтад заасан хураамжийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг **2019 оны 10 сарын 23-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө ***Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд*** ирүүлнэ.

Үнийн саналыг ***2019 оны 10 сарын 23 өдөр 10 цаг 30 минутад*** нээнэ.

Тендерийн нээлтэд сонирхсон этгээд оролцох эрхтэй бөгөөд тендерт оролцогч системд нэвтрэн орж тендерийн нээлттэй танилцах эрхтэй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

<https://tender.gov.mn>

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>а. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг доор жагсаав.<br>Үүнд:<br>✓ Компанийн танилцуулга<br>✓ Улсын гэрчилгээний хуулбар/нотариатаар баталгаажуулсан/<br>✓ Сангийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт<br>✓ Татварын ерөнхий газрын цахим тодорхойлолт<br>✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт<br>✓ Бараа нийлүүлэлтийн хуваарь<br>✓ Албаны ёсны дистрибьютерын гэрчилгээ<br>✓ Нийлүүлэх бараа материалын үзүүлэлт, Баталгаат хугацааны талаарх мэдээлэл |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           |   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | <b>4.1.</b> Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | <b>5.1.</b> Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br><b>5.2.</b> Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | <b>6.1.</b> Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь дараах мэдээллийг үнийн саналын хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан /2017,2018 он аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>2. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл</li> <li>3. Сүүлийн хоёр жилийн /2017, 2018 он/ аль нэг жилд борлуулалтын орлого 50,000,000 тавин сая/-аас багагүй байх</li> <li>4. Улсын гэрчилгээний хуулбар/нотариатаар баталгаажуулсан/</li> <li>5. Татварын ерөнхий газрын цахим тодорхойлолт</li> <li>6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт</li> <li>7. Бараа нийлүүлэлтийн хуваарь</li> <li>8. Нийлүүлэх бараа материалын үзүүлэлт, Баталгаат хугацааны талаарх мэдээлэл</li> <li>9. Баталгаат хугацааны талаарх мэдээлэл</li> </ol> <ul style="list-style-type: none"> <li>• Бусад нэмэлт шаардлага; <ul style="list-style-type: none"> <li>✓ Компанийн танилцуулга</li> </ul> </li> </ul> <p>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг Тендер нь Цахим тендер шалгаруулалт журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем / <a href="https://tender.gov.mn/">https://tender.gov.mn/</a>-д өөрийн аж ахуйн нэгжийн нууцлалын кодоор нэвтрэн орж цахим хэлбэрээр ирүүлнэ. Холбоо барих утас: 70041371-243, 263</p> <p>Огноо: <i>2019 оны 10 сарын 23 өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 00 минут</i> <i>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p style="text-align: center;"><b>Монгол улс, Улаанбаатар хот , Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14-р байр “Диспетчерийн үндэсний төв ХХК” 5-р давхарын хурлын өрөө</b></p> <p>Огноо: <i>2019 оны 10 сарын 23 өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 30 минут</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй</i></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**IP модуль (IPMUX2L), шилэн кабелийн хувиргагч (MOXA EDS508A-SS-SC), цахим хэрэгслийн материал худалдан авах ажиллагааны техникийн шаардлага**

**Үндэслэл:** Одоо ажиллаж байгаа IPMUX2L, MOXA EDS508A-SS-SC, FIB-E1R-SC-20A/B төхөөрөмжүүд нь байгууллагын аваарийн нөөцөнд бэлэн байхгүй бөгөөд гэмтэл гарсан үед шууд сольж тавих боломжгүй байна. Дээр дурдсан төхөөрөмжүүд нь Монгол улсад бэлэн зарагддаггүй зөвхөн гадаадаас захиалгаар авдаг, үүнд тодорхой хугацаа шаардагддаг тул аваарийн нөөцөнд худалдан авч бэлэн байлгах, гэмтэл гарсан үед шууд сольж тавих боломжийг бүрдүүлсэн байх шаардлагатай.

Д/д	Нэр	Маяг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	Медиа конвертор эсвэл дүйцэхүйц	MOXA EDS508A-SS-SC	ш	1	Тех.тодорхойлолтыг үзнэ үү.
2	Медиа конвертор эсвэл дүйцэхүйц	FIB1-E1R-SC-20A/B	ком	1	Тех.тодорхойлолтыг үзнэ үү.
3	IP модуль эсвэл дүйцэхүйц	IPMUX2L/1E1/X21	ш	1	Тех.тодорхойлолтыг үзнэ үү.

### Техникийн тодорхойлолт:

#### 1.MOXA EDS508A-SS-SC




Model name: **EDS508A-SS-SC**  
10/100BaseT(X) ports, RJ45 connector: **6**  
100BaseFX ports (Single mode SC connector): **2**  
Standart: **IEEE 802.3**  
Industrial protocol: **Ethernet/IP, ModbusTCP, Profinet**  
Operating voltage: **9.6 - 60 VDC**  
Dimensions: **80.2 x 135 x 105 mm**  
Weight: **1040 g**  
Operating temperature: **0 - +60C**

### 2.FIB1-E1R-SC-20A/B



Product type: **FIB1 family**  
 Interface type: **E1R**  
 Connection type: **SC**  
 Connectivity distance: **\*20A: 20km**  
 (\*20A must use couple with 20B)  
 Standart: E1: ITU-T G.703  
 G.823; T1: G.703  
 TR-624118, ANSI T1.403  
 Power: **9V,1A**  
 Dimensions: **85.6 x 122.6 mm**  
 Weight: **300g**

### 3.FIB1-E1R-SC-20A/B



Product name: **RAD/IPmux2L**  
 Serial port: **1 /X.21 /**  
 Ethernet port: **Copper 10/100 BaseT**  
 Connector: **RJ-45**  
 E1 interface: **1 or 2**  
 Compliance: **ITU-T G.703**  
 Signaling: **CAS**  
 Operating Temperature: **-40~80**  
 Power: **220 VAC**  
 Dimensions: **217 x 170 x 43 mm**  
 Weight: **500g**

**Үндэслэл:** Засвар үйлчилгээний зориулалтаар /гэмтэл засварын судалгаанд үндэслэн жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу/ өвлийн бэлтгэл ажлын хүрээнд бүрдүүлэх багаж хэрэгсэл, радио деталь, сэлбэг материалын жагсаалт:

№	Багаж хэрэгсэл, сэлбэг материалын нэрс	Хэм-жих нэгж	Тоо, шир-хэг	Тайлбар
1	Багаж /тусгай түлхүүр, бахь, отверка, кусочка/	ком	2	Засвар үйлчилгээ
2	Төрөл бүрийн тэжээлийн блок /9В,12В, 24В,48В/	ш	15	LCD дэлгэц, ӨҮХ, СКАДА-ийн тоноглолын тэжээл орлуулах
3	Хөргөх сэнс 12В, 3 утастай, 45х45х10мм	ш	6	ДС панелийн шулуутгах блок
4	Хөргөх сэнс 12В, 3 утастай, 40х40х20мм	ш	10	МУКС МР2100-гийн тэжээлийн блок
5	Цахилгааны монтажийн кабель /2Х8.0мм <sup>2</sup> /	м	50	UPS, ДС панелийн цахилгаан монтажийг шинээр хийх
6	Транзистор IXFH26N60	ш	10	ДС панелийн шулуутгах блок засах

7	Диод DSEP60-06	ш	10	DC панелийн шулуутгах блок засах
8	Транзистор KT808BM	ш	12	ӨҮХ-ы АДАСЭ, АВС-3, МУС-80 төхөөрөмжийн тэжээлийн гаралт
9	Транзистор IRF640	ш	20	ДС панел удирдах блок тэжээл засах
10	Конденсатор 47-470/60В	ш	100	Засвар үйлчилгээ
11	Гагнуурын тугалга	боодол	1	Засвар үйлчилгээ
12	Телефоны трубкины шнур	ш	10	Засвар үйлчилгээ
13	Цахилгааны лент	ш	20	Засвар үйлчилгээ
14	Кросс кабель	м	100	Телефон цэг
15	Гибрид чип IWS4805-SEG	ш	3	MUX-ийн тэжээлийн блок
16	UPS-ийн хөргөх сэнсний мотор R2E220-AA40-71	ком	2	Тэжээлийн UPS-ийн хөргөлтийн сэнсний мотор
17	Шилэн кабелийн залгааны багажны электрод	ком	1	Ашиглалтын хугацаа дууссан



**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

№	Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1		2	3	4	5	6	7	8
1	Медиа конвертор эсвэл дүйцэхүйц	MOXA EDS508A-SS-SC	1	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
2	Медиа конвертор эсвэл дүйцэхүйц	FIB1-E1R-SC-20A/B	1	ком	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45хоногт	
3	IP модуль эсвэл дүйцэхүйц	IPMUX2L/1E1/X21	1	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас45хоногт	
4	Багаж /тусгай түлхүүр, бахь, отверка, кусочка/		2	ком	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
5	Төрөл бүрийн тэжээлийн блок /9В, 12В, 24В, 48В/	9В, 12В, 24В, 48В	15	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
6	Хөргөх сэнс 12В, Зутастай, 45х45х10мм	12В, Зутастай, 45х45х10мм	6	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
7	Хөргөх сэнс 12В, Зутастай, 40х40х20мм	12В, Зутастай, 40х40х20мм	10	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
8	Цахилгааны монтажийн кабель /2х8.0мм <sup>2</sup> /	/2х8.0мм <sup>2</sup> /	50	метр	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
9	Транзистор IXFH26N60	IXFH26N60	10	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
10	Диод DSEP60-06	DSEP60-06	10	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
11	Транзистор КТ808ВМ	КТ808ВМ	12	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
12	Транзистор IRF640	IRF640	20	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
13	Конденсатор 47-470/60В	47-470/60В	100	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
14	Гагнуурын тугалга		1	боодол	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
15	Телефоны трубоканы шнур		10	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
16	Цахилгааны лент		20	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
17	Кросс кабель		100	метр	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
18	Гибрид чип IWS4805-SEG	IWS4805-SEG	3	ширхэг	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
19	UPS-ийн хөргөх сэнсний мотор R2E220-AA40-71	R2E220-AA40-71	2	ком	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	
20	Шилэн кабелийн залгааны багажны электрод		1	ком	ДҮТ ХХК	Гэрээний дагуу	Гэрээ байгуулсанаас 45 хоногт	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах<br>болон<br>турших                                   | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны<br>нийлүүлэлт<br>ба баримт<br>бичгийн<br>бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны<br>өмчийн эрх   | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх,<br>тээврийн<br>баримт бичиг<br>ирүүлэх        | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат<br>засварын<br>хугацаа                            | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна.  |
| 6. Гэрээнд<br>өөрчлөлт<br>оруулах                              | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа<br>нийлүүлэх<br>хуваарь                               | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги<br>оногдуулах                                       | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ<br>биелүүлээгүй<br>-гээс гэрээг<br>цуцлах           | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг<br>шийдвэрлэх                                    | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. Барааг хүлээлгэн өгөхдөө холбогдох эрх бүхий албан тушаалтанд бүрэн бүтэн байдал, ажиллагааг шалгуулж, зөвшөөрлийг авсан байна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 4) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Нийлүүлэгч баталгаат засварын хугацаанд үнэ төлбөргүй оношилгоо, үйлчилгээ хийнэ. Шаардлагатай тохиолдолд эд ангиудыг үнэ төлбөргүй шинээр сольж өгнө.**
- 4. Төлбөр (ГЕН – 7)** 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт, мөн гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичиг болон санхүүгийн баримт, бараа хүлээж авсан актыг үндэслэн төлнө.**
- Гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлж буй бараа бүрэн ажиллагаатай эсэхэд үндэслэн гэрээний төлбөрийг урьдчилгаа төлбөрийн нөхцөлгүйгээр барааг бүрэн хүлээлгэж өгсний дараа нийлүүлэгчид төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>** 9.1. Алданги оногдуулах хувь: **0.1**
- Алдангийн нийт дүн: **10%**

---

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[нийлүүлэгчийн нэр]* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]*-г (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

#### **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

---

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.